



ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ
ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН
ШҮҮХИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС


ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ

САНАЛ АСУУЛГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН



Агуулга

УДИРТГАЛ.....	2
(1) Судалгааны зорилго, хамрах хүрээ.....	2
(2) Судалгааны мэдээлэл цуглуулсан арга.....	2
(3) Судалгааны түүвэр, байршил.....	2
(4) Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах ажиллагаа.....	3
(5) Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт.....	3
НЭГ. ШҮҮХЭД ХЭРЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА, ХУРАЛДААН ХОЙШЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН.....	4
ХОЁР. ШҮҮХИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ	6
ГУРАВ. ШҮҮХИЙН БАЙР, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СЭТГЭЛ ХАНАМЖ	
ДӨРӨВ. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ШУДАРГА БАЙДАЛ, ХАРААТ БУС БАЙДАЛ	12
ТАВ. ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦААШИД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ.....	15
ДҮГНЭЛТ	16
ХАВСРАЛТ	19



УДИРТГАЛ

2013 онд шинэчлэн байгуулагдсан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн үйлчилгээг ил тод нээлттэй, хүртээмжтэй болгох, олон нийтийн хяналтыг тогтоох нөхцөлийг бүрдүүлэх, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх байдалд онцгой анхаарч ирсэн. Энэ хүрээнд 2014 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүх ба олон нийт” хөтөлбөрийг баталж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Мөн 2017 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт олон нийтийн санал асуулга явуулах тухай тушаал баталсан бөгөөд уг судалгааг жилд 2 удаа хийдэг.

2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” санал асуулгын агуулгад шүүх хуралдааны хойшлох байдал, шүүхийн шударга байдал, шүүхийн тамгын газрын үйлчилгээ, үйл ажиллагаа зэрэг зүйлсийг нэмж оруулсан. Мөн урьд нь 2 төрлийн санал асуумжаар авдаг байсан бол 1 төрлийн асуумжаар, зөвхөн шүүхээр үйлчлүүлсэн иргэдээс авч байхаар болсон.

(1) Судалгааны зорилго, хамрах хүрээ

Шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгоход энэ судалгааны зорилго оршино.

Дээрх зорилгод үндэслэн олон нийтийн санаа бодлыг дараах байдлаар томъёолж, мэдээлэл цуглуулав. Үүнд:

- Шүүхэд хэрэг маргаан шийдвэрлэх хугацаа, хуралдаан хойшлох нөхцөл байдал, шалтгаан;
- Шүүхийн үйлчилгээ, хүндрэл, бэрхшээл;
- Шүүхийн байр, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, сэтгэл ханамж;
- Шүүхэд итгэх иргэдийн итгэл, шударга байдал, хараат бус байдал;
- Шүүхийн үйл ажиллагаанд цаашид тулгарч буй сорилт;

(2) Судалгааны мэдээлэл цуглуулсан арга

Судалгааны мэдээллийг Монгол Улсын нийт шүүхийн хэмжээнд социологийн судалгааны санал асуулгын аргыг ашиглан гүйцэтгэв.

Анкетын судалгаа: Олон нийтийн үнэлэмжийг бодитой тогтоож, цаашид үйл ажиллагааны чиглэлийг тогтоож, шүүхийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх арга замыг тодорхойлоход асуулгын судалгааны аргыг ашигласан бөгөөд нийгмийн судалгааны бусад аргуудыг хавсарсан байдлаар ашиглаагүй болно.

(3) Судалгааны түүвэр, байршил

Судалгааг 21 аймаг, 9 дүүрэг нэлэнхүй байдлаар гүйцэтгэсэн бөгөөд Монгол Улсын бүх шатны нийт 42 шүүхийн тамгын газраар үйлчлүүлсэн 3622 иргэн оролцсон байна. /Дэлгэрэнгүй задаргааг хавсралтаас үзнэ үү/.

(4) Судалгааны мэдээлэл цуглуулах, боловсруулах ажиллагаа

Бүдүүвч 1. Судалгааны ажлын арга зүйн зураглал



Мэдээллийн нууцлалыг хангах: Санал асуулгыг авахдаа иргэд олон нийтээс бусдын нөлөөлөлд автахгүй байх, өөрийн үзэл бодлоо нээлттэй, шударгаар илэрхийлэх боломжоор хангаж ажилласан /Дэлгэрэнгүй задаргааг хавсралтаас үзнэ үү/.


(5) Судалгаанд оролцогчдын хүн ам зүйн үзүүлэлт

График 1. Судалгаанд хамрагдсан төлөөлөл



Судалгаанд нийт 3622 хүн хамрагдсан байснаас 72 хувь иргэн, 13 хувь нь өмгөөлөгч, 5 хувь нь прокурор, 10 хувь нь хэргийн бусад оролцогч нар хамрагдаж үнэлгээ өгөхийн зэрэгцээ санал бодлоо хуваалцжээ.

График 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг болон хүйс



Судалгаанд оролцсон хүмүүсийн 33 хувь нь 25-34 настай, 26 хувь нь 35-44 настай, 20 хувь нь 45-54 настай, 11 хувь нь 55-аас дээш настай, 10 хувь нь 18-24 настай байна. Шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн хувьд нийтлэг байдлаар 35 дээш настай хүмүүс 67 орчим хувийг эзэлж байна. Хүйсын хувьд жигд буюу эмэгтэй эрэгтэйн харьцаа 49:51 байна.


НЭГ. ШҮҮХЭД ХЭРЭГ МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ХУГАЦАА, ХУРАЛДААН ХОЙШЛОХ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ШАЛТГААН

График 3. Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлсэн төрөл



Судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн ½ нь буюу 50 хувь нь иргэний хэргийн, 24 хувь нь эрүүгийн хэргийн, 10 хувь нь захиргааны хэргийн шалтгаан ханддаг бол 16 хувь нь бусад шалтгаанаар үйлчлүүлсэн гэжээ.

График 4. Шүүхэд анх хандсанаас хойш хэдий хугацаа өнгөрч байгаа эсэх



Шүүхэд хэрэг маргаан шийдвэрлүүлэхээр болон шүүхээс үйлчилгээ авахаар хандсан хугацааны хувьд ялгаж харвал, 38 хувь нь 1 сар дотор, 21 хувь нь 1-2 сар, 15 хувь нь 3-5 сар, 9

хувь нь 6-8 сар, 4 хувь нь 9 сараас 1 жил, 5 хувь нь 1-2 жил, 8 хувь нь 2 жилээс дээш хугацаа зарцуулж байна гэжээ. Хэрэг маргаан шийдвэрлэх хугацаа процессын хуулиндаа 90-180 хоног гэвэл 6 сараас дээш хугацаа зарцуулж байгаа хэрэг маргаан шүүх дээрх нийт хандаж буй хэрэг маргааны $\frac{1}{4}$ -ийг буюу 26 хувийг эзэлж байна.

Харин шүүх хуралдаан хойшилсон байдлыг тандаж үзвэл судалгаанд хамрагдсан нийт шүүхээр үйлчлүүлсэн 3622 хүний 35 хувь нь буюу 1268 хүний оролцсон шүүх хуралдаан хойшилсон гэжээ. Тэдний 32 хувьд 1 удаа, 28 хувьд нь 2 удаа, 32 хувьд нь 3-5 удаа, 6 хувьд 6-10 удаа, 2 хувьд нь 11-ээс дээш удаа тус тус шүүх хуралдаан нь хойшилсон гэжээ. (график 5)

График 5. Шүүх хуралдаан хойшилсон тоо



Шүүх хуралдаан хойшилж байгаа шалтгааныг аль субъектээс шалтгаалж байгаа талаар судалгаанд оролцсон хүмүүсээс тодруулж үзвэл дараах байдлаар хариулсан байна.

График 6. Шүүх хуралдаан хэнээс болж хойшилсон бэ?



Судалгаанд оролцсон хүмүүсийн 55 хувь нь шүүх хуралдаан хэнээс болж хойшилсон талаар асуултад хариулаагүй үлдээсэн бол $\frac{1}{4}$ нь буюу 900 гаруй хүн нь хэргийн оролцогчдоос, 14 хувь нь өмгөөлөгчөөс, 4 хувь нь шүүгчээс, 2 хувь нь прокуророос гэжээ. Хоосон орхисон хэсэгт шүүх хуралдааны танхим, ажлын ачаалал зэрэг асуултад байхгүй шалтгаан зэрэг орсон байхыг үгүйсгэхгүй. Харин яг хэргийн оролцогч, өмгөөлөгч, шүүгч, прокуророос болж хойшил байгаа

хүндрэл, бэрхшээл тулгарсан” гэж хариулж байсан нь 29.3 хувь болж 2.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2013 оноос эхлэн хэрэгжүүлсэн шүүхийн шинэчлэлийн хүрээнд нийслэл, орон нутаг дахь шүүхийн хэргийн ачааллыг тэнцвэржүүлэх үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2019 оны бүтэн жилийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд хэргийн ачаалал дүүргийн шүүхийн нэг шүүгчид 138.9 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 86.1 хэрэг, иргэний хэргийн шүүхийн хувьд дүүргийн шүүхийн нэг шүүгчид 286.1 хэрэг, орон нутгийн шүүхийн нэг шүүгчид 246 хэрэг, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэргийн ачаалал нь харилцан адилгүй бөгөөд нийслэл дэх захиргааны хэргийн шүүхийн нэг шүүгчид 60 хэрэг, орон нутагт байрлах дийлэнх шүүхийн хувьд 1 шүүгчид 11.8 хэрэг тус тус ногдож байгаа юм¹. Захиргааны хэргийн шүүхийн хувьд нийслэлд 6 дахин, эрүү болон иргэний хэргийн шүүхийн хувьд нийслэлд тус бүр 20-40 орчим хувиар өндөр ачаалалтай байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлсөн гол хүчин зүйл байж болох талтай.

Түүнчлэн төвлөрсөн хот, суурин газар болохын хувьд нийслэл дэх шүүхүүдийн шийдвэрлэж буй хэргүүд илүү ээдрээ, төвөгтэй байхыг үгүйсгэхгүй. Цаашид нийслэл дэх шүүхүүдээр үйлчлүүлсэн иргэдийн хувьд тулгарсан нийтлэг бэрхшээлийг нарийвчлан судалж, илрүүлэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Судалгаанд оролцогчдын 1/5 буюу 21.9 хувь нь шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарсан гэж хариулсан нь нийт шүүхүүдийн үйлчилгээнд дутагдалтай тал, сайжруулах зүйлүүд байгааг харуулж байна. Тулгарсан хүндрэл, бэрхшээлийг дараах байдлаар томъёолсон байна. Үүнд:

График 9. Ямар бэрхшээл тулгарсан эсэх



¹ Монгол Улсын шүүхийн 2019 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг авч үзвэл тэдгээр нь хэргийн бусад оролцогч болон шүүхийн дэд бүтэц, шүүхийн тамгын газрын үйл ажиллагаатай аль алинтай нь холбогдож байна.

Хэргийн оролцогчдын хувьд шүүхийн хүндрэл бэрхшээл учрах байдалд ¼ харьцах нөлөөтэй гэж судалгаанд оролцсон шүүхээр үйлчлүүлэгч үзсэн бол шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны тухайд судалгаанд оролцогчдын 18.9 хувь нь шүүхийн үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг авч чадаагүй, 18.3 хувь нь шүүхийн байр, танхимын хүрэлцээ тааруу, 11.7 хувь нь ажилтнуудын /захиргааны ажилтны/ харьцаа хандлага тааруу, 10 хувь нь шүүхийн зохион байгуулалт, төлөвлөлт хангалтгүй, 7.5 хувь нь шүүгч, ажилтнуудын мэдлэг, чадвар тааруу гэжээ. Иймээс шүүхийн тамгын газрууд дээрх байдлыг сайжруулах, ажилтнуудын харьцаа хандлагын тал дээр анхаарч сургалт, сурталчилгаа явуулахын зэрэгцээ иргэд олон нийтийн эрх зүйн ухамсрыг төлөвшүүлэх, шүүхийн байгууллагын үйлчилгээний талаарх мэдлэг, мэдээллийг түгээх арга хэмжээ авах шаардлага зайлшгүй байна.

График 10. Ямар нэг бэрхшээл тулгарсан эсэх /Нийслэл, орон нутаг/




Шүүхээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхэд гарч буй нийтлэг хүндрэлүүдийг орон нутаг болон нийслэлд байрлах шүүхүүдээр харьцуулж үзвэл өндөр үзүүлэлттэй байгаа гурван асуудлын нэг нь орон нутагт илүү, хоёр асуудал нь нийслэлд илүү байгааг харж болно. “Шүүхийн үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээллийг авч чадаагүй” гэсэн байдал орон нутагт байрлах шүүхүүдийн хувьд нийслэлд байрладаг шүүхээс 2 дахин илүү байна. Мөн нөгөө талдаа нийслэлд байрлах шүүхийн “Хэргийн бусад оролцогчоос шалтгаалж бэрхшээл гарсан”, “Шүүхийн байр, танхимын хүрэлцээ тааруу” гэж шүүмжлэх үнэлгээ орон нутгийнхаас өндөр байна.

Дээрх байдал нь нийслэлд байрлах шүүхүүдийн ажлын ачаалал өндөр, шүүхээр үйлчлүүлэгчдийн тоо их байгаатай холбоотой бөгөөд ажлын ачаалал, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, нийслэл дэх шүүхийн дэд бүтцийг сайжруулах зайлшгүй шаардлага, хэрэгцээ байгааг иргэдээс авсан судалгааны үр дүн илтгэж байна. Харин орон нутагт байрлах

шүүх, шүүхийн тамгын газрууд нь шүүхийн үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд орон нийтэд түгээх шаардлагатай байгааг илтгэж байна.

ГУРАВ. ШҮҮХИЙН БАЙР, ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, СЭТГЭЛ ХАНАМЖ


График 11. Шүүхийн байр болон шүүх хуралдааны танхимаар үйлчлүүлэхэд танд тухтай байсан уу?



Судалгаанд оролцсон шүүхээр үйлчлүүлэгчдийн 1/5 д нь шүүхийн байр болон шүүх хуралдааны танхимын тухай тухтай байдал нийцээгүй байна. Үүнийгээ тэд дараах саналаар илэрхийлсэн байна. Үүнд:

- Шүүх хуралдааны танхим жижиг, агааржуулалт, дулаан байдал муу
- Танхимын хүрэлцээ муу, хүлээлт үүсдэг
- Өмгөөлөгч нарын тусгаарласан, хавтаст хэрэгтэй танилцах өрөө байхгүй
- Сандал, ширээ зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг . . . зэрэг голлох шалтгаануудыг дурдсан байна.

График 12. Та шүүхээс авсан үйлчилгээндээ хэр зэрэг сэтгэл ханамжтай байна вэ?



Шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн иргэд, өмгөөлөгч, прокурор, бусад оролцогч нараас шүүхийн үйлчилгээний талаар үнэлгээг авахад тэдний 22 хув нь маш их, 46 хувь нь ер нь сэтгэл ханамжтай, 19 хувь нь дунд зэрэг, 2 хувь нь сэтгэл ханамжгүй, 2 хувь нь сэтгэл ханамжгүй, гомдолтой гэж тус тус үнэлсэн бол 9 хувь буюу 350 орчим хүн нь энэ талаар үнэлж мэдэхгүй байна гэжээ. Үүнийг шүүхийн тамгын газар тус бүрээр харьцуулж үзвэл: Говьсүмбэр аймгийн тамгын газар тэргүүлж Баянхонгор аймгийн тамгын газар сүүл мушгисан байна.

Хүснэгт 1. Шүүхээс авсан үйлчилгээний сэтгэл ханамжийн түвшин, бүх шүүхээр харьцуулав.


№	Шүүхийн тамгын газар	Оноо
1	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	4.45
2	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.38
3	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.37
4	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	4.35
5	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	4.34
6	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.31
7	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	4.29
8	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.18
9	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	4.17
10	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар	4.10
11	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	4.09
12	Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар	4.08
13	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	4.05
14	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	4.02
15	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.02
16	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.02
17	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар	4.00
18	Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар	4.00
19	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	3.99
20	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар	3.99
21	Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар	3.94
22	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	3.94
23	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	3.93
24	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	3.91
25	Нийт шүүхийн дундаж	3.91
26	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.87
27	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар	3.86
28	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар	3.81
29	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.80
30	Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар	3.80
31	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	3.78
32	Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.71
33	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.70
34	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	3.69
35	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.65
36	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	3.65
37	Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.64

38	Улсын дээд шүүхийн тамгын газар	3.61
39	Багахангай, Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	3.59
40	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.56
41	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.47
42	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.45
43	Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар	3.15

Жич: Шүүхүүдийн сэтгэл ханамжийн түвшинг гаргахдаа:

- *Маш их сэтгэл ханамжтай* – 5 оноо
- *Ер нь сэтгэл ханамжтай* – 4 оноо
- *Дунд зэрэг* – 3 оноо
- *Сэтгэл ханамжгүй* – 2 оноо
- *Сэтгэл ханамжгүй, гомдолтой байна* – 1 оноо өгөх байдлаар гаргалаа.


График 13. Шүүхийн үйл ажиллагааны үнэлгээ



Судалгаанд оролцсон шүүхээр үйлчлүүлэгчдээс шүүхийн үйл ажиллагааны талаар 6 үзүүлэлтийн дагуу үнэлгээг авахад, эдгээр үзүүлэлтүүд жигд 76-83 хувиар сайн болон маш сайн үнэлгээг авсан байна. Үүнээс ялгаж харвал хэрэг маргааныг зөв, шударга шийдвэрлэсэн байдал нь бусдаасаа бага үнэлгээ авсан бол өргөдөл гомдол, хүлээн авах бүртгэх ажиллагааны байдал өндөр үнэлгээг нь авчээ.

ДӨРӨВ. ШҮҮХЭД ИТГЭХ ИРГЭДИЙН ИТГЭЛ, ШУДАРГА БАЙДАЛ, ХАРААТ БУС БАЙДАЛ


График 14. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин



Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн талаар судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн 31 хувь нь бүрэн итгэлтэй, 43 хувь нь ер нь итгэж байна, 16 хувь нь дунд зэрэг, 3 хувь нь итгэдэггүй, 1 хувь нь огт итгэхгүй байна гэж тус тус хариулжээ. Харин 6 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй гэжээ.

Өмнөх жилийн үр дүнг харьцуулж үзвэл, энэ төрлийн судалгааг 4 удаа хийхдээ хариултын хувьд 4 шкаллаар авсан учир бага зэрэг өөр байдлаар харагдаж байна. (График 15.)

График 15. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин (2017.01-2019.06)



Шүүхийн шинэтгэл хэрэгжиж эхлэхээс өмнө буюу 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 хувиас бага байдаг байсан бол 2017 оноос хийсэн судалгаагаар 63-67 хувийн үзүүлэлтээр шүүхэд итгэдэг гэж хариулсан боловч энэ нь **2018-2019 оны хооронд 3 орчим хувиар шүүхэд итгэх иргэдийн итгэл суларсан боловч энэ удаагийн судалгаар шүүхэд итгэдэг байдал 74 хувь болж 10 орчим хувиар өссөн гэж хэлж болохоор байна.** (бүрэн итгэлтэй байдаг+итгэлтэй байдаг) Энэ нь шүүхэд итгэх итгэлийг хэмжих хамгийн гол үзүүлэлт мөн.

Энэ үзүүлэлт өмнөх судалгаа(2017-2019)-ны дүнгээс 10 орчим хувиар өссөн байдлыг дараах байдлаар тайлбарлаж болохоор байна. Өмнөх судалгааг шүүхээр үйлчлүүлж байсан болон **үйлчлүүлж байгаагүй иргэдээс** авдаг байсан бол энэ судалгааг **зөвхөн шүүхээр үйлчлүүлсэн**

иргэд, өмгөөлөгч, прокурор, хэргийн бусад оролцогч буюу гэрч, хариуцагч, иргэдийн төлөөлөгч нараас авсан учир илүү шүүхийн талаар бодит мэдээлэлтэй хүмүүс хамрагдсан гэж хэлж болно. Учир нь шүүхэд итгэдэггүй (4%), эргэлзэж байна буюу дунд зэрэг (16%) гэж үнэлсэн байдал нь өмнөх 2017-2019 оны дүнтэй зөрүүгүй боловч хэлж мэдэхгүй байна гэж үзэх хувь 16 хувиас 6 хувь болтол буурсан байна. Энэ нь шүүхэд итгэдэг гэж үзэх хувь 10 хувиар өссөн байдал руу шилжиж орсон байна. **Шүүхээр үйлчлүүлээгүй хүмүүсээс шүүхийн талаарх үнэлгээг авах нь шүүхийн талаар бодит мэдээлэлгүй, нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэт улс төржсөн мэдээлэлд автаж бодит бусаар үнэлэх эрсдэл дагуулж байна.**

Мөн шүүхэд итгэх иргэдийн итгэл нь тогтмол хөдөлгөөнгүй үзүүлэлт биш тул цаашид иргэдийн итгэлийг сулруулахгүй, үзүүлэлтийг бууруулахгүй байх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй юм.

Хүснэгт 2. Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин, бүх шүүхээр харьцуулав.


№	Шүүхийн тамгын газар	Оноо
1	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.44
2	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	4.40
3	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	4.40
4	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар	4.38
5	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	4.38
6	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.38
7	Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар	4.36
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.32
9	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	4.31
10	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.28
11	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	4.27
12	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	4.25
13	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	4.21
14	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар	4.19
15	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.15
16	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	4.14
17	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	4.14
18	Багахангай, Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	4.14
19	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.13
20	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар	4.13
21	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	4.11
22	Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар	4.10
23	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	4.08
24	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	4.07
25	Нийт шүүхийн дундаж	4.07
26	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	4.04
27	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар	4.03
28	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	4.01
29	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.00
30	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	4.00
31	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар	3.99
32	Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар	3.99
33	Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар	3.97
34	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	3.96
35	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.95
36	Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.94

37	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.85
38	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.84
39	Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.83
40	Улсын дээд шүүхийн тамгын газар	3.73
41	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	3.64
42	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	3.59
43	Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар	3.22

Жич: Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшинг гаргахдаа:


- Бүрэн итгэлтэй байдаг – 5 оноо
- Итгэлтэй байдаг – 4 оноо
- Дунд зэрэг итгэлтэй байна – 3 оноо
- Итгэдэггүй – 2 оноо
- Огт итгэдэггүй – 1 оноо өгөх байдлаар гаргалаа.

График 16. Шүүх иргэдийг ялгаварлахгүйгээр тэгш, шударга үйлчилдэг гэж үздэг үү?



Шүүх иргэдийг ялгаварлахгүйгээр тэгш, шударга ханддаг байдалд судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн 26 хувь нь бүрэн санал нийлнэ, 44 хувь нь санал ер нь нийлнэ, 15 хувь нь дунд зэрэг, 5 хувь нь санал нийлэхгүй, 2 хувь нь огт санал нийлэхгүй байна гэж тус тус хариулжээ. Харин 8 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй гэжээ.

График 17. Шүүгчид хараат бусаар, өөрийн итгэл үнэмшилээр ажилладаг гэдэгтэй санал нийлэх байдал



Шүүгчид хараат бусаар, өөрийн итгэл үнэмшлээр ажилладаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн 25 хувь нь бүрэн санал нийлнэ, 44 хувь нь санал ер нь нийлнэ, 16 хувь нь дунд зэрэг, 4 хувь нь санал нийлэхгүй, 2 хувь нь огт санал нийлэхгүй байна гэж тус тус хариулжээ. Харин 9 хувь нь энэ талаар хэлж мэдэхгүй гэжээ.

ТАВ. ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЦААШИД ТУЛГАРЧ БУЙ СОРИЛТ

Санал асуулгын энэ хэсэгт шүүхийн шинэтгэлд цаашид бид юун дээр анхаарах шаардлагатай вэ? гэсэн багц асуултыг шүүхээс үйлчлүүлсэн хүмүүсээс асуусан.

График 18. Цаашид шүүхийн ямар үйл ажиллагаанд илүү анхаарал хандуулах шаардлагатай вэ?



Шүүхийн шүүхийн үйл ажиллагааг цаашид анхаарах шаардлагатай чиглэлүүдийн хувьд шүүхээр үйлчлүүлэгчдийн 34.7 хувь нь **шүүгч хараат бусаар ажиллах баталгааг нэмэгдүүлэх нь хамгийн чухал гэж үзжээ**. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлдөг болсноор шүүгчид эрх мэдэл, хөрөнгө чинээтэй хүн дарамтлах маягаар шууд нөлөөлөх явдал буурсан. Гэвч энэ судалгааны үр дүнгээс харахад шүүгчид хувийн танил нь буюу дээд шатны албан тушаалтан гуйх буюу хариу нэхэх хэлбэрээр нөлөөлөх байдал байсаар байна гэж иргэд үзжээ. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөл цаашид шүүгчид нөлөөлдөг танил тал буюу шүүгчдээс нөлөөлөх нөлөөг хаах чиглэлээр ажиллах шаардлагатайг судалгааны дүн харуулж байна.

Шүүхийн шинэтгэлийн хүрээнд 2014 оноос хойш шүүгчдийн бүрэлдэхүүнийг олон шинэ шүүгчээр нэмэгдүүлсэн ч иргэдийн зүгээс шүүгчдийн мэдлэг, ур чадвар хангалтгүй гэж үзэж байгаа хувь өндөр хэвээр байна. Эдгээр нь цаашид шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, шүүгчдийн мэдлэг, ур чадварыг сайжруулах талаар үр дүнтэй ажил төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна.

Цаашид Шүүгч хараат бус ажиллах баталгааг бүрдүүлэх (34.7%) болон мэдлэг чадвартай шүүгчээр шүүхийн хүний нөөцийг бэхжүүлэх (26.8%), шүүхэд хандах иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатай (24.5%) гэж судалгаанд оролцогчид бусад үзүүлэлтээс илүү үзжээ. Энэ чиглэлээр Шүүхийн ерөнхий зөвлөлийн хийсэн ажлын үр дүнд сүүлийн жилүүдэд дэвшил гарсан. Энэ үйл явцыг улам гүнзгийрүүлж шүүх ба олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээлэл, сурталчилгааг эрчимжүүлэх шаардлага байгааг тус судалгаа илтгэж байна. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийг цахимжуулах, шүүхийг үйлчилгээний байгууллага болгох ажлыг эрчимжүүлэх, хүнд суртлыг арилгах, үйл ажиллагааг хялбар, дөт, иргэдэд ойлгомжтой болгох чиглэлээр урт хугацааны шат дараалсан бодлого, арга хэмжээ авах шаардлагатай юм. Улсын Их Хурал, Засгийн газар ч шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх ажилд анхаарах шаардлагатайг энэ судалгаанаас харж болно.

ДҮГНЭЛТ

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүх ба олон нийтийн харилцааг бэхжүүлэх, эргэх холбоо тогтоох, шүүхэд итгэх иргэдийн итгэлийг дээшлүүлэх, шүүхийн ил тод нээлттэй байдлыг хангах, шүүхийн үйлчилгээнд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор явуулсан санал асуулгын судалгаанд бүх шатны шүүхийн 42 тамгын газраар үйлчлүүлсэн иргэн, прокурор, өмгөөлөгч болон хэргийн бусад оролцогч зэрэг нийт 3622 хүн хамрагдсан. Энэ санал асуулгын үр дүнг боловсруулж дараах дүгнэлтийг танилцуулж байна.

ШЕЗ-ын Ажлын алба энэ төрлийн тандалт маягийн судалгааг 2014 оноос эхэлсэн бөгөөд энэ удаагийнх нь 2017 оноос “Шүүхэд итгэх иргэдийн итгэл” сэдэвт олон нийтийн санал асуулга явуулах тухай ШЕЗ-ийн даргын тушаалын дагуу хийгдсэн 5 дахь судалгаа юм. Зарим голлох үзүүлэлтүүдийг өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулж тооцсон.

Шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байна

Энэ санал асуулгын судалгаагаар шүүхээр үйлчлүүлсэн хүмүүсийн **74 хувь шүүхэд итгэдэг** гэсэн үзүүлэлт гарсан нь шүүхэд итгэх иргэдийн итгэл сайн байгааг харуулж байна. Энэ нь өмнөх онд хийгдсэн судалгааны дүн (64.8%)-ээс 10 орчим хувиар өссөн үзүүлэлт юм. Харин шүүхийн шинэтгэл эхлэхээс өмнөх 2007 оны судалгаагаар шүүхэд итгэх иргэдийн итгэл 30 орчим хувьтай байсан бол 2015 оны байдлаар иргэдийн итгэл 60-80 хувь болж өссөн гэсэн хөндлөнгийн байгууллагын судалгааны үр дүнг бататгасан хэвээр байна.

Судалгаагаар шүүх хөрөнгө чинээ, эрх мэдэл, боловсрол зэргээр хүнийг ялгаварладаггүй гэж оролцогчдын 70 хувь нь үзжээ.

Шүүхэд хандсан хүмүүсийн ¼ нь буюу 26 хувь нь 6 сараас дээш хугацаа зарцуулж байна.

Шүүхээр үйлчлүүлж буй хүмүүс хэрэг маргаанаа шийдвэрлүүлж чадахгүй удах, сунжрах тохиолдол их байна. Энэ нь иргэдэд шүүхийн талаар сөрөг ойлголт, хандлага үүсгэж байна. Мөн шүүх хуралдааныг хойшилж байгаа шалтгаан нь хэргийн оролцогчид (шүүгч, өмгөөлөгч, прокурор, иргэн) гэхээсээ илүүтэйгээр субъектив хүчин зүйлээс хамааралтай байна гэж үзжээ. Учир нь судалгаанд оролцогчдын 55 хувь нь шүүх хуралдаан хойшилж буй шалтгааныг хэргийн оролцогчоос биш шалтгаанаар хойшилж байна гэж үзсэн.

Шүүхээр үйлчлүүлэхэд хүндрэл бэрхшээл тулгардаг эсэх байдал 1/5 нь байна. Энэ үзүүлэлт 2017 онд 24 хувь байсан бол энэ удаагийн судалгаагаар 21 хувь байна.

Энэ үзүүлэлт нь 6 сар тутамд 1 орчим хувиар буурсан буюу сайжирч байна. Харин шүүхээр үйлчлүүлэхэд хэргийн бусад оролцогчдоос шалтгаалсан бэрхшээл, шүүхийн үйлчилгээний талаарх шаардлагатай мэдээлэл авч чаддаггүй, шүүхийн байр, танхимын хүрэлцээ тааруу гэсэн шалтгаануудаас болж асуудал үүсдэг байна.

Харин шүүхийн үйлчилгээ өмнөхөөсөө мэдэгдэхүйц сайжирч байна, эвлэрүүлэн зуучлал үр дүнтэй хэрэгжиж байна, шүүхийн үйлчилгээнд цахим инновац нэвтэрсэн, шүүхийн шийдвэр нээлттэй, үйл ажиллагаа нь ил тод болсон гэдэгтэй иргэдийн олонх санал нийлдэг.

Шүүхийн тамгын газраар үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшин сайн байна. 1-5 оноогоор дүгнэвэл 3.91 буюу – В үнэлгээ гэж хэлж болно.

Нийслэлд байх шүүхүүдийн тамгын газрын үнэлгээ тааруу байгаа бол орон нутагт байх шүүхүүдийн тамгын газрын үнэлгээ өндөр байна. Энэ нь хүн ам зүйн нягтрал, хэргийн ачаалал зэрэгтэй холбогдож байна. Мөн тамгын газрын тав тухгүй байдалд дараах саналыг бичгээр гаргасан байна. Үүнд:

- *Шүүх хуралдааны танхим жижиг, агааржуулалт, дулаан байдал муу*
- *Танхимын хүрэлцээ муу, хүлээлт үүсдэг*
- *Өмгөөлөгч нарын тусгаарласан, хавтаст хэрэгтэй танилцах өрөө байхгүй*
- *Сандал, ширээ зэрэг шаардлагатай тоног төхөөрөмж дутмаг . . . зэрэг голлох шалтгаануудыг дурдсан байна.*

Иргэд цаашид шүүхийн үйл ажиллагаанд шүүгч хараат бусаар ажиллах баталгааг нэмэгдүүлэх, мэдлэг чадвартай шүүгчээр шүүхийн хүний нөөцийг бэхжүүлэх, шүүхэд хандах иргэдийн эрх зүйн мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх хамгийн тулгамдаж буй асуудал гэж үзжээ. Иймд эдгээр чухал өөрчлөлтийг иргэдэд мэдрүүлэх, ойлгуулах ажлыг нэмэгдүүлэх шаардлага байгааг илтгэнэ.

Судалгааны үр дүнд тулгуурлаж дараах товч зөвлөмжийг гаргаж байна.

- Шүүхийн нэр хүнд, шүүгчид итгэх олон нийтийн итгэл буурах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг тогтмол өсгөх чиглэлд төлөвлөгөөт арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх;
- Шүүх, шүүхийн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээллийн нэгдсэн арга зүй, загвартай болж үйлчлүүлж буй иргэдэд байнга танилцуулдаг байх;
- Шүүгчийн хараат бус ажиллах баталгааг бий болгох, хариуцлагын тогтолцоог сайжруулах;
- Шүүгчид нөлөөлдөг нөлөөллийг багасгах, “нөлөөллийн мэдүүлэг” бөглөдөг тогтолцоог улам боловсронгуй болгох, энэ талын үйл ажиллагааг идэвхжүүлж иргэд олон нийтэд сурталчлах;
- Шүүгчийн тоог нэмэгдүүлэх, шүүхийн ачааллыг тэнцвэржүүлэх;

- Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоог сайжруулах, шүүхийн ажилтнуудыг урьдчилж бэлтгэдэг институттэй болох, шүүхийн хүний нөөцийн шинэтгэлийг гүнзгийрүүлэх;
- Шүүхийн үйлчилгээг орчин үежүүлэх чиглэлээр төсөв хөрөнгийг шийдвэрлэх, шүүхийн мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг сайжруулах;
- Шүүхийн дэд бүтэц, нэн ялангуяа нийслэл дэх шүүхүүдийн дэд бүтцийг оновчтой бүрдүүлж, шүүхээр үйлчлүүлэгч иргэд шүүхийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй авах боломжийг бүрдүүлэх;

Судалгааны үр дүнг тооцож, тайлан бичсэн: Д.Аюуш /ШСМСХ-ийн Социологич-судлаач/



ХАВСРАЛТ

Хүснэгт №3. Судалгаанд хамрагдсан хүний тоо

№	Шүүхийн тамгын газар	Санал асуулгын тоо
1	Улсын дээд шүүхийн тамгын газар	101
2	Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	100
3	Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тамгын газар	99
4	Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	102
5	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	100
6	Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	100
7	Баянгол, Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	100
8	Багахангай, Налайх дүүргийн шүүхийн тамгын газар	100
9	Багануур дүүргийн шүүхийн тамгын газар	98
10	Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	98
11	Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	100
12	Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар	98
13	Архангай аймаг дахь шүүхийн тамгын газар	90
14	Баян-Өлгий аймаг дахь шүүхийн тамгын газар	90
15	Баянхонгор аймаг дахь шүүхийн тамгын газар	88
16	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	60
17	Булган аймаг дахь шүүхийн тамгын газар	90
18	Говь-Алтай аймаг дахь шүүхийн тамгын газар	90
19	Говьсүмбэр аймаг дахь шүүхийн тамгын газар	90
20	Дархан-Уул аймаг дахь давж заалдах шатны шүүхийн тамгын газар	89
21	Дархан-Уул аймаг дахь анхан шатны шүүхийн тамгын газар	90
22	Дорнод аймаг дахь шүүхийн тамгын газар	90
23	Дорноговь аймаг дахь шүүхийн тамгын газар	90
24	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	60
25	Дундговь аймаг дахь шүүхийн тамгын газар	92
26	Завхан аймаг дахь шүүхийн тамгын газар	90
27	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	59
28	Орхон аймаг дахь шүүхийн тамгын газар	90
29	Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газар	65
30	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	60
31	Өмнөговь аймаг дахь шүүхийн тамгын газар	90
32	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	60
33	Сүхбаатар аймаг дахь шүүхийн тамгын газар	90
34	Сэлэнгэ аймаг дахь шүүхийн тамгын газар	89
35	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	60
36	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	62
37	Төв аймаг дахь шүүхийн тамгын газар	84
38	Увс аймаг дахь шүүхийн тамгын газар	90
39	Ховд аймаг дахь шүүхийн тамгын газар	90
40	Ховд аймгийн Булган сум дахь Сум дундын шүүхийн тамгын газар	62
41	Хөвсгөл аймаг дахь шүүхийн тамгын газар	90
42	Хэнтий аймаг дахь шүүхийн тамгын газар	86
	Нийт	3622